



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/85

Цагаан-Уул сум

Г 7

**Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай
тэмцэх ажлыг зохион
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, 10.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Засгийн газрын 190 дугаар тогтоол, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын “Үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэх хуваарь батлах тухай” 2024 оны 02 дугаар сарын 15-ний А/96 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын 2024 оны А/161 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд бэлчээрийн хөнөөлт мэрэгч их хэмжээгээр тархсан Агар, Өвгөд, Хужирт, Шарга багийн өвөлжөө, хаваржааны бүс нутагт нийт 6666 мянган га талбайд 10 тн бактержуулсан будааг цацах микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг 2024 оны 05 дугаар сарын 06-ний өдрөөс эхлэн 2024 оны 05 дугаар сарын 22-ний өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Багуудын бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг, хяналт тавих ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Багуудын үлийн цагаан оготнын устгал хийх талбайн хэмжээ, бактержуулсан будааны хуваарилалтыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

4. Мэрэгч амьтантай тэмцэх ажилд иргэд, малчдын бүлэг хоршоог хамруулж тэднийг үлийн цагаан оготно устгалын гарын авлага, шаардлагатай хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, микробиологийн аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах болон цаг агаарын саатлаас бусад тохиолдолд ажил саатахгүй байх бэлтгэл ажлын зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (У.Аварзэд)-д үүрэг болгосугай.

5. Үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг зохион байгуулах, эргүүл жижүүр хийх, хорио цээрийн дэглэм хэрэгжүүлэх ажилд тухайн багийн малчдыг татан оролцуулах захирамж гаргаж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Агар багийн Засаг дарга (Г.Маналжав) Өвгөд багийн Засаг дарга (Б.Дэлгэрмөрөн), Хужирт багийн

Засаг дарга (Ч.Дэрмэн), Шарга багийн Засаг дарга (Б.Бямба-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

6. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаярт) даалгасугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ